



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 4 сарын 10 өдөр

Дугаар 50

Улаанбаатар хот

Г Оноосон нэр өөрчлөхийг зөвшөөрөх тухай Г

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 04 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 6.20 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Ард Секьюритиз ҮЦК” ХХК-ийн оноосон нэрийг “Ард Секьюритиз ҮЦК” ХХК болгон өөрчлөхийг зөвшөөрсүгэй.

2. Компанийн оноосон нэрийг өөрчилсөнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Ард Секьюритиз ҮЦК” ХХК /Ж.Золзаяа/-д үүрэг болгосугай.

1/ Компанийн оноосон нэрийн өөрчлөлт, шинэчилсэн дүрмийг холбогдох журмын дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, хувийг Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 15 хоногийн дотор ирүүлэх;

2/ Компанийн оноосон нэр өөрчлөгдсөн талаарх мэдээллийг харилцагч, үйлчлүүлэгчид болон “Монголын хөрөнгийн бирж” ХК, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК, “Арилжааны төлбөр тооцоо” ХХК-д тус тус хүргэх.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН